



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/619

Есөнбулаг

Цэргийн дүйцүүлэх албанаас  
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан (Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам)-ын 5.3, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Цэргийн дүйцүүлэх албанд 2021 онд элсэн орж алба хаах хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан газарт ирээгүй, оногдуулсан үүргийг биелүүлэхээс зайлсхийж цэргийн штабтай байгуулсан гэрээ болон дүйцүүлэх албаны журмыг удаа дараа зөрчиж тайлан мэдээ ирүүлээгүй Дашравдангийн Хосбаяр (ДА98122313), Алтаннарын Шаравжамц (ДЮ99052234), Нэргүйн Даваа (ДН97120811) нарыг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөр дуусгавар болгон гэрээг цуцлан цэргийн дүйцүүлэх албанаас хассугай.

2.Цэргийн дүйцүүлэх албанаас хасагдсан иргэдтэй тооцоог хийж захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб, хурандаа (Д.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР